

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№3 (10)

2021.06.14

## УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЦАХИМ УУЛЗАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛАВ



Монголын МСС Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх цогц хөтөлбөрийн хүрээнд зураг төсөл боловсруулах, барилга, угсралтын ажил гүйцэтгэх олон улсын нээлттэй тендер шалгаруулалтууд зарлахаар төлөвлөж буйтай холбоотойгоор гадаад, дотоодын компани, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгөх зорилго бүхий хоёр удаагийн цахим уулзалтыг [Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Америкийн худалдааны танхим, Монголын бизнесийн зөвлөл, Франц-Монголын худалдааны танхим, Герман-Монголын бизнесийн эрхлэгчдийн холбоо, Монгол-Энэтхэгийн бизнесийн зөвлөл, Австралийн худалдааны танхим, Монгол-Солонгосын эдийн засгийн форум ТББ-тай](#) хамтран амжилттай зохион байгууллаа. Гадаад, дотоодын компани, аж ахуйн нэгжүүд, хамтран зохион байгуулагч байгууллагуудын нийт 100 гаруй төлөөлөл оролцож мэдээлэл авав. Уулзалтаар дэд бүтцийн хоёр төсөл болох Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл болон Хаягдал ус дахин боловсруулах төслийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж байгаа Газрын доорх усны эх үүсвэрийн худгууд болон ус дамжуулах шугам хоолойн барилга угсралтын ажил гүйцэтгэх тендер, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулж, барилга угсралтын ажил гүйцэтгэх тендер, тендер шалгаруулалтын үйл явц, тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангасан тендерийн санал бэлтгэн ирүүлэхэд анхаарах зүйл болон холбогдох бусад журмын талаар мэдээллийг танилцууллаа.

[Эх сурвалж: Монголын Мянганы сорилтын сан](#)

## Д.СУМЪЯАБАЗАР: СЭЛБЭ ГОЛЫН АЙ САВД НЭМЖ ГАЗАР ОЛГОХГҮЙ



Ойрын өдрүүдэд орсон бороо, цасны улмаас Сэлбэ гол үерлэсэнтэй холбоотойгоор Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар газар дээр нь очиж ажиллалаа. Сүхбаатар дүүргийн хэмжээнд үерийн голдирол, жалга, судаг дагуу буусан 1200 орчим айл байдаг. Тухай бүрд мэдэгдэх хуудас өгч, холбогдох байгууллагууд шаардлага тавьдаг ч айлууд нүүдэггүй. Өнгөрсөн удаагийн борооны улмаас л гэхэд олон айл усанд автаж, айлуудын жорлон хальсныг соруулжээ. Их хэмжээний үер болбол айлууд нэлэнхүйдээ усанд автахаар байгааг албаныхан хэлж

байлаа. Энэ үеэр Хотын дарга Сэлбэ гол орчимд Байгаль орчны үнэлгээ хийлгэж, голын хамгаалалтын бүсэд олгосон газрын захирамжийг цуцлах, үер усны гамшгаас хамгаалах ажлыг эрчимжүүлэхийг, түүнчлэн Сэлбэ голын ай савд нэмж газар олгохгүй байхыг холбогдох албаныханд үүрэг болголоо.

[Эх сурвалж: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар](#)

## ӨМНӨГОВЬ, ДУНДГОВЬ АЙМГИЙН УНДНЫ УСНЫ ЧАНАРЫН ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭВ

Монгол Улсын Засгийн газрын 474 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн, хүн амын унд ахуйн усны чанарт тавих хяналтыг сайжруулж, ундны усны стандартын шаардлага хангасан усаар хүн амыг хангах ажлын хүрээнд Зохицуулах зөвлөлөөс санаачлан ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэн, Хими-химийн технологийн хүрээлэнгүүдтэй хамтран "Монгол Улсын Ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах, технологийн шийдэл сонгох төсөл"-ийг хэрэгжүүлж байгаа билээ. Одоогийн байдлаар тус төслийг нийт 6 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжүүлээд байна. Энэхүү төслийн хүрээнд Өмнөговь, Дундговь аймгуудын ундны усны чанарын төслийн суурь судалгааны ажлыг эхлүүлэхээр болж, Зохицуулах зөвлөлийн даргын удирдамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг 2021 оны 5 дугаар сарын 24-30 өдрүүдэд Өмнөговь, Дундговь аймгуудын Засаг дарга болон холбогдох нийтийн аж ахуйн байгууллагуудтай уулзаж, хамтран ажиллах талаар санал солилцжээ.

[Эх сурвалж: Усны үйлчилгээг зохицуулах зөвлөл](#)

## НИЙСЛЭЛИЙН УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ 80 ХУВИЙНХ НЬ АШИГЛАЛТЫН ХУГАЦАА ДУУСЧЭЭ

Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжууд ус зайлуулах хоолой дутмаг байдгаас жил бүрийн борооны улиралд авто замын элэгдэл, гудамж талбайн эвдрэл үүсдэг. Өнөөдрийн байдлаар нийслэлийн есөн дүүргийн хэмжээнд нийт 1100 км авто зам байдгаас ердөө 187 орчим км буюу 17 орчим хувь нь л борооны ус зайлуулах шугам сүлжээтэй. Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа ус зайлуулах шугам сүлжээний 80 хувь нь 1970-1980 оны хооронд баригдсан бөгөөд тэдгээрийн ашиглалтын хугацаа бүрэн дууссан байна. Тиймээс хотын одоогийн гудамж, замын сүлжээг гол болон туслах замаар нь эрэмбэлэн ус зайлуулах шугам сүлжээ тавих ажлыг төлөвлөсөн бөгөөд ингэхдээ гадаргуун усыг цэвэршүүлж байгальд урсгах технологи нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа талаар мэдээллийг албаны хүмүүс өгчээ. Олон улсад борооны ус зайлуулах олон шийдэл байдаг. Тухайлбал, Япон улс цардмал зам ашигладаг бөгөөд энэ нь нарны халаалтаар агшиж сунадаг, усыг өөртөө шингээдэг материал байдаг байна.

[Эх сурвалж: МонголТВ](#)

## ТОВЧХОН

УСУГ Дусалхүү подкастынхаа ээлжит дугаарыг [“Усны тоолуурын баталгаат хугацаа, баталгаажуулалтын ач холбогдол”](#), [“Боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдийн ангилал, тавигдах ерөнхий шаардлага”](#) сэдвээр хүргэж байна. Подкастын зочноор Хэрэглэгчдэд үйлчлэх албаны Усны тоолуурын лабораторийн техникч Д. Ганбаяр болон Бохирдуулагч үйлдвэрийн хяналтын инженер Г.Үүрийнгэгээ нар тус тус оролцож дээрх сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ [Эх сурвалж: УСУГ](#)